

Энэхүү хичээлийн арга зүйн санаа нь ээлжит хичээлийг төлөвлөх, заах багшийн арга зүйг сайжруулах, сурагчдын сурлагын амжилтыг ахиулах, сургууль, багш нар сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Даалгавар: Дараах уран бүтээлийн зохиомжийн төрөл, утга санааг тайлбарлан бичнэ үү?



Сурагчдын гүйцэтгэл: (2018 он, Боловсролын хүрээлэн, “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны сурагчдын сорилын гүйцэтгэлийн үр дүнгээс)

	Гүйцэтгэлийн хувь	Дундаж хувь
Зохиомжийн төрөл, зургийн утга санааг тайлбарласан	15.3	48.5
Зурагт дүрслэгдсэн зүйлсийг тоочин нэрлэсэн	72.4	
Огт тайлбарлаж чадаагүй	12.3	

Хичээл: Дүрслэх урлаг

Анги: 8 дугаар анги,

Бүлэг сэдэв:

Соёлын үнэт зүйл

Агуулга:

Монголын зураачдын уран зураг унших

Дүгнэлт: Даалгаврын сурагчдын дундаж гүйцэтгэлийг авч үзэхэд 48.5 хувьтай гэхдээ хангалттай гүйцэтгэсэн сурагчдын эзлэх хувь тун бага байна. Сурагчдын 85 орчим хувь нь зохиомжийн төрлийг тодорхойлж, утга санааг баримтад тулгуурлан үр дүнтэй тайлбарлаж чадаагүй байгаа нь уран зураг унших агуулгын хэрэгжилт сул байгааг илтгэж байна.

Уран зураг унших агуулгаар сурагчдад дүрслэх урлагийн бүтээлийн үнэ цэнийг олж харах, өөрсдийн амьдрал дахь дүрслэх урлагийн холбоо хамаарлыг ухааран ойлгуулахын зэрэгцээ дүрслэх урлагийн хичээлээр эзэмшвэл зохих гол чадваруудыг хөгжүүлдэг. Иймээс тухайн агуулгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор (сурагчид дүрслэх урлагийн бүтээлд идэвхтэй ажиглалт хийх, бодох эргэцүүлэх, бүтээлийг өөрсдийнхөөрөө ойлгож утга өгөх, холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар уран бүтээлийг ойлгох, үнэлэх) энэхүү арга зүйн санааг боловсруулан хүргэж байна.

Суралцахуйн зорилт: 8.3а. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийг таньж тодорхойлох (1921 оноос өнөөг)

Үе шат	Арга зүйн санаа
<p>1. Мэдрэх, хүлээн авах</p>  <p>О.Цэвэгжав, “Азарганы ноцолдоон” 1958 он</p> <p>Урлагийн бүтээлээр дамжуулан сурагчдын, сонирхлыг төрүүлэх, мэдрэмж, төсөөллийг хөгжүүлэх</p>	<p>1. Сурагчид уран зургийг харж ажиглах, өөрийнхөөрөө ойлгох, утга өгөх</p> <p>а. Уран зургийг ажиглах</p> <p>б. Уран зургийн талаар эргэцүүлэн бодох- өөрийнхөөрөө ойлгох, утга өгөх</p> <p>в. Өөрт төрсөн анхны санаагаа илэрхийлэх</p>  <p>Чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Зураг дээр юу дүрсэлсэн болохыг тоочин нэрлэнэ үү? • Уран бүтээлийн гол ба туслах дүрийг зургийн хавтгайн аль хэсэгт хэрхэн байрлуулсныг тодорхойлно уу? • Зохиомжийн ямар аргыг ашигласан байна вэ? • Зургийн өнгө зохицлыг өөрийн бодлоор тодорхойлон хэлнэ үү? • Зургийн гол агуулга нь юу вэ? Хэрхэн илэрхийлсэн байна вэ? • Тухайн зургийн талаарх өөрт төрсөн сэтгэгдлээ илэрхийлнэ үү?

<p>2. Бүтээлч эрэл хайгуул хийх</p> <p>Сурагчид өөрсдийн анхны санаагаа хөгжүүлэх</p>	<p>2. “Азарганы ноцолдоон” уран бүтээлийн талаар судалгаа хийх</p> <p>а. Мэдээлэл цуглуулах</p> <ul style="list-style-type: none"> ✓ Уг бүтээлийн талаарх баримт материал, холбогдох цахим болон хэвлэмэл мэдээлэл ✓ Мэргэжлийн болон олон нийтийн зураачийн үзэл бодол, уран бүтээлд өгсөн хөндлөнгийн үнэлгээ г.м. <p>б. Мэдээлэлд боловсруулалт хийх</p> <p>Чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Уран бүтээлчийн тухай ✓ Уран бүтээл хэрхэн бий болсон бэ? ✓ Бүтээлийн гол агуулга, илэрхийлэмж юу вэ? ✓ Зургийн өнгө зохицол, зохиомжийн шийдэл тухай ✓ Бусад уран бүтээлүүдээс ялгагдах онцлог юу вэ? ✓ Уран бүтээлийн чанар чансаа, одоо хаана хадгалагдаж байгаа эсэх
<p>3. Ойлгох/ үнэлэх</p> <p>Суралцагчид уран зургийн үнэ цэнийг олж харах, өөрсдийн амьдрал дахь дүрслэх урлагийн холбоо хамаарлыг ойлгох</p>	<p>3. “Азарганы ноцолдоон” уран бүтээлийн талаар хэлэлцэх</p> <div data-bbox="491 757 624 875" data-label="Image"> </div> <p>а. Сурагчид уран бүтээлийн судалгаа хийхээс өмнөх болон дараах төсөөллөө харьцуулан ярилцах, мэдээлэл боловсруулсан үр дүнгээ танилцуулах, өөрсдийн санаагаа нотолгоонд үндэслэн хуваалцах</p> <p>б. Тухайн уран бүтээлийн онцлогийг хамтран тодорхойлох</p>

Бататгал хичээлийн арга зүйн санаа:



“Азарганы ноцолдоон зургийг хэн өөрийнхөөрөө сайн зурах вэ?” сэдвээр сэдэвт зураг зурах

- ✓ Тухайн уран бүтээлийн талаарх судалгаа, хэлэлцүүлгийн үр дүнг эргэцүүлэх
- ✓ Эскиз хийх (зурах зургаа урьдчилан төсөөлөх, хэд хэдэн хувилбараар эскиз хийх)
- ✓ Эх зургаа зурах (Зурах дэвсгэртийн байрлал, зохиомж зөв сонгох (хэвтээ) босоо)
- ✓ Өөрийн бүтээлийн агуулга, утга санаа, шийдэл болон зурсан арга, ажиллагааг бүтээлийн онцлогийг бусаддаа танилцуулах

Багшид зориулсан нэмэлт зөвлөмж:

Багш идэвхтэй ажиглалт хийхэд чиглүүлнэ. Сурагч нэг бүрийн оролцоог хангах үүднээс өөрийн бодол, санаагаа бичих даалгавар өгч болно. Бичих нь бодол, санаагаа цэгцлэх, өргөжүүлэх боломжийг олгодог. Сурагч суралцах явцдаа зөвхөн мэдлэгийг цээжлэх бус олон янзын бодлоор дамжуулан эзэмшдэг ба мэдлэг, бодол хоёр салшгүй зүйл юм. Бодлыг буй болгох үр дүнтэй асуултууд хичээлийн үйл ажиллагааны явцад тун чухал. Сурагчид уран зургийн талаарх өөрийн санаагаа илэрхийлэх үед багш тэдний хариултыг зөв, буруу гэх мэтээр дүгнэх болон шүүмжлэхгүй. Мөн асуултад багш өөрөө хариулт өгөх ёсгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Багш суралцагчдын оролцоог хангах үүднээс багийн гишүүдийг урьдчилан дугаарласан байх ба хариултыг авахдаа гишүүдийн дугаараас сугалах байдлаар хэлэлцүүлгийг зохион байгуулж болно. Суралцагчдад хэлэлцүүлгийн явцад гарсан чухал санааг дэвтэртээ тэмдэглэн авах даалгаврыг өгнө. Энэ нь хэлэлцүүлгийн үр нөлөөг дээшлүүлэх нөгөө талаар хэлэлцүүлгийн дараа тухай сэдвээр өөрийн үзэл бодол байр сууриа илэрхийлэх, асуудал дэвшүүлэх зэрэгт ач холбогдолтой. Шинэ санаа гаргасан, өөрийн бүтээлдээ хөгжүүлэлт хийсэн сурагчдыг дэмжих, урамшуулах нь чухал байдаг.

Хэрэглэсэн эх сурвалж:

Боловсролын хүрээлэн. (2019). “ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны тайлан. Улаанбаатар.

БСШУСЯ. (2019). Суурь боловсролын сургалтын хөтөлбөр. Урлаг.110-112 тал. Улаанбаатар. www.mier.mn

Боловсролын хүрээлэн. (2019). ЕБС-ийн “Дүрслэх урлаг”-ийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж”. 14 тал. Улаанбаатар. www.mier.mn

МУБИС. (2017). Отгонтуяа.С., “Бага боловсролын дүрслэх урлагийн сургалтын хөтөлбөрийн чиг хандлага ба хэрэгжилтийн асуудалд”. Урлаг, биеийн тамир, технологийн боловсролын хөгжлийн чиг хандлага олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 220-221 тал. Улаанбаатар.

(2015). БНМАУ-ын Ардын зураач, Төрийн хошой шагналт Очирын Цэвэгжав. Улаанбаатар. Мөнхийн үсэг ХХК.

<https://mn.wikipedia.org>

Боловсруулсан: С.Отгонтуяа